

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2025/044/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Аудитор: Л.Мөнх-Оргил  
Утас: 99039344 Цахим хаяг: [munkh-orgill@audit.gov.mn](mailto:munkh-orgill@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 1/103  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.АМАРТҮВШИН ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 557,837.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар орон тоо хэтрүүлэн ажилласан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд 2 албан шаардлага, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн, ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчилд 2 зөвлөмжийг хүргүүллээ.

#### Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Засаг даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 91.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

8725021238

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>190,909,731.28</b>	<b>244,078,564.53</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>16,978,200.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	16,827,981.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>150,219.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	150,219.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>189,957,231.28</b>	<b>191,047,864.53</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>11,023,400.00</b>	<b>11,023,400.00</b>
35130	Эм боох материал	11,023,400.00	11,023,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>152,933,831.28</b>	<b>154,024,464.53</b>
35410	Бичиг хэргийн материал	97,500.00	62,500.00
35420	Аж ахуйн материал	7,156,480.00	7,156,480.00
35450	Барилгын засварын материал	3,199,000.00	3,199,000.00
35470	Бусад хангамжийн материал	142,480,851.28	143,606,484.53
35600	Мал амьтад	26,000,000.00	26,000,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>952,500.00</b>	<b>36,052,500.00</b>
36300	Тэжээлийн нөөц	00.00	35,100,000.00
36600	Бусад нөөц	952,500.00	952,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,233,235,216.22</b>	<b>4,072,856,082.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,233,235,216.22</b>	<b>4,072,856,082.44</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,123,637,579.42</b>	<b>3,963,283,445.64</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,179,666,058.00	3,693,002,202.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-561,365,100.12	-656,447,508.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	397,617,366.00	799,717,366.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-171,353,553.00	-233,677,243.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,317,550.40	226,610,550.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,361,913.15	-118,373,269.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,927,857.22	44,315,357.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,364,587.61	-22,462,212.18
39209	Зам, гүүрийн байгууламж	32,000,000.00	60,720,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-12,799,999.92	-20,198,999.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	246,591,974.50	302,608,510.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-78,502,260.73	-112,795,494.28
39217	Ном	264,187.83	264,187.83
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>109,597,636.80</b>	<b>109,572,636.80</b>
39301	Програм хангамж	2,967,000.00	2,967,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,942,000.00	-2,967,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	109,572,636.80	109,572,636.80
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,424,144,947.50</b>	<b>4,316,934,646.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>5,600,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>5,600,000.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>5,600,000.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>00.00</b>	<b>5,600,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	5,600,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,424,144,947.50</b>	<b>4,311,334,646.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,424,144,947.50</b>	<b>4,311,334,646.97</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,010,256,554.27	3,010,256,554.27
51101	Өмч: - төрийн	3,010,256,554.27	3,010,256,554.27
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>218,044,774.16</b>	<b>1,105,234,473.63</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	218,044,774.16	218,044,774.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	887,189,699.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	195,843,619.07	195,843,619.07
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,424,144,947.50</b>	<b>4,316,934,646.97</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,552,988,040.80</b>	<b>2,490,995,824.25</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>269,108,342.80</b>	<b>1,073,435,813.25</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>269,108,342.80</b>	<b>1,073,435,813.25</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	269,108,342.80	1,073,435,813.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	269,108,342.80	1,073,435,813.25
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,283,879,698.00</b>	<b>1,417,560,011.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>297,776,098.00</b>	<b>119,585,111.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,696,978.00	82,787,530.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	293,079,120.00	36,797,581.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>986,103,600.00</b>	<b>1,297,974,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	986,103,600.00	1,297,974,900.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,426,598,425.38</b>	<b>1,603,806,124.78</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,426,598,425.38</b>	<b>1,603,806,124.78</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,144,338,561.05</b>	<b>1,410,047,448.47</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>429,528,368.88</b>	<b>644,310,884.73</b>
210101	Үндсэн цалин	306,769,872.49	442,894,910.48
210102	Нэмэгдэл	88,571,367.95	191,297,074.25
210104	Урамшуулал	34,187,128.44	10,118,900.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,691,048.91</b>	<b>79,491,207.96</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,509,907.11	51,061,830.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,295,283.60	9,189,733.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,436,226.91	3,227,218.62
210204	Ажилгүйдлийн даатгал	859,056.77	3,892,412.82
210205	Эрүүл мэндийн даатгал	8,590,574.52	12,120,012.77
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,908,560.50</b>	<b>54,101,807.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,789,712.50	16,026,655.00
210302	Түлш, халаалт	32,118,848.00	38,075,152.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>67,397,961.00</b>	<b>49,204,888.00</b>
210401	Бичиг хэрэг	7,368,000.00	3,735,000.00
210402	Тээвэр, шатахуун	44,476,831.00	30,179,518.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,320,000.00	4,445,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,863,200.00	6,625,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,522,200.00	4,219,650.00
210408	Бараа материал акталсны зардал	5,847,730.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>53,124,660.00</b>	<b>38,067,940.00</b>
210604	Урсгал засвар	53,124,660.00	38,067,940.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,200,000.00</b>	<b>4,775,747.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,200,000.00	4,775,747.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>242,026,376.00</b>	<b>196,098,409.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,966,651.00	190,575,468.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,209,600.00

**Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	1,674,236.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,474.00	550,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,170,000.00
210807	Газрын төлбөр	186,015.00	1,343,341.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>248,461,585.76</b>	<b>343,996,564.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,292,380.00	114,764,251.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	218,169,205.76	229,232,313.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>282,259,864.33</b>	<b>193,758,676.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,431,800.00</b>	<b>70,695,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,098,100.00	38,086,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,333,700.00	32,609,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>254,828,064.33</b>	<b>123,063,576.31</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>126,389,615.42</b>	<b>887,189,699.47</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,221,083.49</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,221,083.49	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-1,221,083.49</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>125,168,531.93</b>	<b>887,189,699.47</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	-384,155,049.57	2,822,187,549.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	2,986,730.00	2,986,730.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,010,256,554.27	-381,168,319.57	2,825,174,279.02
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	543,000,878.75	543,000,878.75
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	218,044,774.16	3,424,144,947.50
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	218,044,774.16	3,424,144,947.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,010,256,554.27	218,044,774.16	3,424,144,947.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	887,189,699.47	887,189,699.47
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	1,105,234,473.63	4,311,334,646.97

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,283,879,698.00</b>	<b>1,412,432,030.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,283,879,698.00</b>	<b>1,412,432,030.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>297,776,098.00</b>	<b>114,457,130.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,696,978.00	82,787,530.00

**Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	293,079,120.00	31,669,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>986,103,600.00</b>	<b>1,297,974,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	986,103,600.00	1,297,974,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,255,894,898.00</b>	<b>1,363,039,030.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,255,894,898.00</b>	<b>1,363,039,030.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>973,038,533.67</b>	<b>1,169,280,353.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>427,150,132.69</b>	<b>644,310,884.73</b>
210101	Үндсэн цалин	306,769,872.49	442,894,910.48
210102	Нэмэгдэл	88,571,367.95	191,297,074.25
210104	Урамшуулал	31,808,892.25	10,118,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,333,689.48</b>	<b>79,491,207.96</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,389,811.46	53,849,587.43
210202	Тэтгэмжийн даатгал	4,235,619.39	6,401,976.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,388,915.60	3,227,218.62
210204	Ажилгүйдлийн даатгал	847,399.86	3,892,412.82
210205	Эрүүл мэндийн даатгал	8,471,943.17	12,120,012.77
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,408,560.50</b>	<b>54,101,807.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,789,712.50	16,026,655.00
210302	Түлш, халаалт	32,118,848.00	38,075,152.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,572,506.00</b>	<b>50,724,888.00</b>
210401	Бичиг хэрэг	6,169,000.00	3,700,000.00
210402	Тээвэр, шатахуун	35,700,806.00	30,179,518.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,320,000.00	4,445,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,382,700.00	6,625,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	5,774,650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>51,057,000.00</b>	<b>38,807,940.00</b>
210604	Урсгал засвар	51,057,000.00	38,807,940.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,200,000.00</b>	<b>4,775,747.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,200,000.00	4,775,747.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>290,757,145.00</b>	<b>174,112,409.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	287,727,260.00	168,589,468.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,209,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,674,236.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,474.00	550,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,170,000.00
210807	Газрын төлбөр	156,175.00	1,343,341.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,559,500.00</b>	<b>122,955,470.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,559,500.00	122,955,470.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>282,856,364.33</b>	<b>193,758,676.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,028,300.00</b>	<b>70,695,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,098,100.00	38,086,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,930,200.00	32,609,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>254,828,064.33</b>	<b>123,063,576.31</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	254,828,064.33	123,063,576.31

**Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,984,800.00	49,393,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,985,000.00	49,393,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,985,000.00	49,393,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,985,000.00	49,393,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,985,000.00	49,393,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-27,985,000.00	-49,393,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(200.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,303,974,900.0	1,209,384,966.7	94,589,933.3	92.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,293,104,900.0	1,209,384,966.7	83,719,933.3	93.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,230,888,400.0	1,147,169,166.7	83,719,233.3	93.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,569,700.0	644,310,884.7	9,258,815.3	98.6
210101	Үндсэн цалин	603,573,100.0	442,894,910.5	160,678,189.5	73.4
210102	Нэмэгдэл	49,996,600.0	191,297,074.3	141,300,474.3	382.6
210104	Урамшуулал	00.0	10,118,900.0	-10,118,900.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,696,200.0	79,491,208.0	2,204,992.0	97.3
210201	Тэтгэврийн даатгал	55,553,400.0	53,849,587.4	1,703,812.6	96.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,535,700.0	6,401,976.3	133,723.7	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,228,600.0	3,227,218.6	2,001,381.4	61.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,307,100.0	3,892,412.8	-2,585,312.8	297.8
210205	Эрүүл мэндийн даатгал	13,071,400.0	12,120,012.8	951,387.2	92.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,750,000.0	52,101,807.0	8,648,193.0	85.8
210301	Гэрэл, цахилгаан	21,250,000.0	16,026,655.0	5,223,345.0	75.4
210302	Түлш, халаалт	38,800,000.0	36,075,152.0	2,724,848.0	93.0
210303	Цэвэр, бохир ус	700,000.0	00.0	700,000.0	-100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	59,489,100.0	58,141,108.0	1,347,992.0	97.7
210401	Бичиг хэрэг	3,700,000.0	3,700,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	29,169,100.0	28,530,738.0	638,362.0	97.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,540,000.0	4,445,000.0	95,000.0	97.9

**Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,080,000.0	6,625,720.0	454,280.0	-06.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000,000.0	14,839,650.0	160,350.0	98.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>74,986,800.0</b>	<b>67,435,940.0</b>	<b>7,550,860.0</b>	<b>89.9</b>
210604	Урсгал засвар	74,986,800.0	67,435,940.0	7,550,860.0	89.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,500,000.0</b>	<b>3,500,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	3,500,000.0	3,500,000.0	00.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>158,963,100.0</b>	<b>122,032,749.0</b>	<b>36,930,351.0</b>	<b>76.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,353,500.0	116,509,808.0	36,843,692.0	76.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209,600.0	1,209,600.0	00.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.0	550,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.0	250,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.0	1,170,000.0	80,000.0	93.6
210807	Газрын төлбөр	1,350,000.0	1,343,341.0	6,659.0	99.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>137,933,500.0</b>	<b>120,155,470.0</b>	<b>17,778,030.0</b>	<b>87.1</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,933,500.0	120,155,470.0	17,778,030.0	87.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,216,500.0</b>	<b>62,215,800.0</b>	<b>700.0</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,216,500.0</b>	<b>62,215,800.0</b>	<b>700.0</b>	<b>100.0</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,086,100.0	38,086,100.0	00.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,130,400.0	24,129,700.0	700.0	00.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,870,000.0</b>	<b>00.0</b>	<b>10,870,000.0</b>	<b>-100.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,870,000.0</b>	<b>00.0</b>	<b>10,870,000.0</b>	<b>-100.0</b>
223001	Бусад хөрөнгө			10,870,000.0	-100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,303,974,900.0</b>	<b>1,209,384,966.7</b>	<b>94,589,933.3</b>	<b>92.7</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,303,974,900.0</b>	<b>1,209,384,966.7</b>	<b>94,589,933.3</b>	<b>92.7</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,303,974,900.0	1,209,384,966.7	94,589,933.3	92.7
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	00.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	00.00	100.0

**Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

620004	Гэрээт ажилтан	04.00	04.00	00.00	00.00
--------	----------------	-------	-------	-------	-------

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

		/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>114,457,130.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>114,457,130.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>71,504,187.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,648,780.00</b>
210401	Бичиг хэрэг	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,648,780.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>60,579,660.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,579,660.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,479,300.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,479,300.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,479,300.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>34,473,643.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	34,473,643.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>114,457,130.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>114,457,130.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,787,530.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,669,600.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

**3. Аудитын илрүүлэлт**

3.1 Аудитаар нийт 22,478.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Малчдад худалдан борлуулсан малын тэжээл долооцыг бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасныг зарцуулалтыг хийлгэж тайланд залруулсан.
- Тайлант онд 2700 ширхэг, нийт 8,100.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг худалдан борлуулсан ба авлага үүсгэж бүртгээгүй байсныг тайланд залруулсан.
- Жаргалант сумын ЭМТ-ийн дарга Л.Баярсайханд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны 10,128.0 мянган төгрөг олгохоос 10,278.2 мянган төгрөг олгосон ба Л.Баярсайханаас илүү олгосон 150.2 мянган төгрөг, Ц.Бямбажаваас 5,127.9 мянган төгрөгийн авлага үүсгээгүй байсныг тайланд авлагыг үүсгүүлэн залруулсан.
- Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Залуу төгөл ХХК-аар ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 80,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж чанарын баталгааны үлдэгдэл 5,600.0 мянган төгрөг авч үлдсэн ба өр төлбөрийг тайланд тусгаагүй байсныг тайланд залруулсан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар 12,265.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага ,2 зөвлөмж хүргүүллээ.

### 3.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 3.3 Албан шаардлага

1. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Биеийн тамирын арга зүйч, Байгаль хамгаалагч гэсэн 2 орон тоо хэтрүүлэн ажилласан байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; заалттай нийцэхгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Өмнөх аудитаар төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн байрших газрыг баталгаажуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ авах, газрын бүртгэлийг газрын гэрчилгээнд заасан хэмжээ болон үнэ цэнээр залруулан бүртгэх, Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх 3 зөвлөмж хүргүүлснээс 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төсвийн зарцуулалттай холбоотой

##### 1.1 Илрүүлэлт:

Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 9,065.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 3,200.0 тус тус хөрөнгө бэлтгэх, шагнал урамшуулалд зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 211 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй, "ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал батлах тухай журмыг дагаж мөрдөх

#### 2. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

##### 2.1 Илрүүлэлт:

Жаргалант сумын ЗДТГ нь ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.10 "Төсвийн байгууллага нь ахмадын санд шилжүүлэх хөрөнгийг төсвийн төлөвлөлтийн Фискал программын "Ахмадын сан" гэсэн зориулалтад тусган батлуулж, тухайн байгууллагын ахмадын санд шилжүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### 2.2 Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг хууль тогтоомжид заасны дагуу байгуулж, дараа жилийн төсвийн төсөлд төлөвлөж, батлуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агуй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын бүртгэлтэй холбоотой	1	3,500.0	1	3,500.0			1	3,500.0		
Авлагын данстай холбоотой	2	13,378.2	2	13,378.2			2	13,378.2		
Өглөгийн данстай холбоотой	1	5,600.0	1	5,600.0			1	5,600.0		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>22,478.2</b>	<b>4</b>	<b>22,478.2</b>			<b>4</b>	<b>22,478.2</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжөөс 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	0			1	0						
Орон тоо хэтрүүлэн ажилласан	1	0			1	0						
Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн	1	12,265.0					1	12,265.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>12,265.2</b>			<b>2</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>12,265.2</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулаагүй	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Л.МӨНХ-ОРГИЛ ОГНОО: